

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 5-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-42

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	6-25
--	------

***Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 11 дүгээр сарын 05-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Да.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 55 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Д.Батбаяр, Х.Булгантуяа, П.Ганзориг, Б.Түвшин.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат, Л.Отгонтуяа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Ш.Бат-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын Б.Мөнхтөр, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Урьболд, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын ерөнхий газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсжаргал, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга С.Баярмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Да.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Номингийн гаргасан, Аудитын дүгнэлтийн 1 дүгээр хавсралтад дурдсан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй нийт 76929.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хасаж, алдагдлыг бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	7
Бүгд:	7

0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор дараах төсөл, арга хэмжээг төслөөс хасаж, хөрөнгийн зардлыг нийт 126,293.4 сая төгрөгөөр бууруулах. Үүнд:

2.1.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 40,000.0 сая төгрөгөөр;

2.2.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800805 төслийн кодтой Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км /Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 106,868.4 сая төгрөг, санхүүжих дүн 20,036.4 сая төгрөгөөр;

2.3.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800888 төслийн кодтой Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Зүүн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 60,156.2 сая төгрөг, санхүүжих дүн 18,046.9 сая төгрөгөөр;

2.4.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170,899.7 сая төгрөг, санхүүжих дүн 25,635.0 сая төгрөгөөр;

2.5.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800770 төслийн кодтой Хатгал-Ханх чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замын эхлэл /Хөвсгөл/, хэрэгжих хугацаа

2026-2028 он, төсөвт өртөг 41,350.1 сая төгрөг, санхүүжих дүн 10,100.0 сая төгрөгөөр;

2.6.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400215 төслийн кодтой Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 8,396.8 сая төгрөг, санхүүжих дүн 3,778.9 сая төгрөгөөр;

2.7.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400239 төслийн кодтой Спорт заалын барилга /Хөвсгөл, Түнэл сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,156.8 сая төгрөг, санхүүжих дүн 970.6 сая төгрөгөөр;

2.8.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400052 төслийн кодтой Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 6,728.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,018.7 сая төгрөгөөр;

2.9.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606700065 төслийн кодтой Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 14,368.5 сая төгрөг, санхүүжих дүн 4,310.6 сая төгрөгөөр;

2.10.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400522 төслийн кодтой Спорт заалын барилга /Ховд, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,103.4 сая төгрөг, санхүүжих дүн 1,396.6 сая төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 7
Бүгд: 7
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор дараах төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааг хойшлуулах буюу хөрөнгийн зардлыг 53,045.4 сая төгрөгөөр бууруулах. Үүнд:

3.1.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200838 төслийн кодтой Гадаадын иргэн, харьяатын газрын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,365.4 сая төгрөг, санхүүжих дүн 1,064.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

3.2.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200992 төслийн кодтой Дотоод хэргийн их сургуулийн цогцолборын Хилийн албаны сургуулийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 21,343.2 сая төгрөг, санхүүжих дүн 6,403.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

3.3.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200865 төслийн кодтой Хилийн цэргийн 0243 дугаар ангийн авто гарааж, авто засварын барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,017.2 сая төгрөг, санхүүжих дүн 1,357.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

3.4.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200851 төслийн кодтой Хилийн цэргийн 0257 дугаар ангийн спорт заалны барилга /Хөвсгөл, Мөрөн сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,078.5 сая төгрөг, санхүүжих дүн 1,385.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

3.5.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200837 төслийн кодтой Хилийн цэргийн ангийн албан хаагчдын орон сууцны барилга /Хөвсгөл, Цагаан-Уул сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 6,534.9 сая төгрөг, санхүүжих дүн 1,960.5 сая төгрөг;

3.6.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200991 төслийн кодтой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны, цагдан хорих байрны барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 6,467.8 сая төгрөг, санхүүжих дүн 1,940.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

3.7.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200355 төслийн кодтой Цагдаагийн газрын барилга /Булган, Булган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 5,353.6 сая төгрөг, санхүүжих дүн 1,606.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

3.8.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200382 төслийн кодтой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны, цагдан хорих байрны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,968.3 сая төгрөг, санхүүжих дүн 1,785.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

3.9.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200517 төслийн кодтой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга /Өвөрхангай, Хархорин сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 14,609.5 сая төгрөг, санхүүжих дүн 3,652.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

3.10.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400274 төслийн кодтой Зэвсэгт хүчний дүгээр ангийн тусгай сургалт бэлтгэлийн төв /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,471.6 сая төгрөг, санхүүжих дүн 1,562.2 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

3.11.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400285 төслийн кодтой Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Баруун бүс/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 19,657.7 сая төгрөг, санхүүжих дүн 7,942.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

3.12.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400293 төслийн кодтой Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 26,586.5 сая төгрөг, санхүүжих дүн 7,976.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

3.13.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400232 төслийн кодтой Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 20,132.1 сая төгрөг, санхүүжих дүн 9,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

3.14.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601501960 төслийн кодтой Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн оюутны дотуур байрын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 18,030.0 сая төгрөг, санхүүжих дүн 5,409.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 7
Бүгд: 7
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын урсгал зардлыг бууруулах хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн тооцооллын хавсралт №15-д тусгагдсан зээлийн хүүгийн татаас буюу Шинэ хоршоо-чинээлэг малчин хөтөлбөрийн зээлийн хүүгийн дэмжлэг 108,954.0 сая төгрөгийг хасаж, гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 7
Бүгд: 7
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Хуралдаан 1 цаг 02 минут үргэлжилж, 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр 10 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим 09 цаг 55 минут.

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Да.Цогтбаатар: 2025 оны 11 сарын 5-ны Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүдийн ирц 58 хувьдаа хүрсэн учраас энэ удаагийн хурлыг эхлүүлье ээ. Дэд хорооныхоо гишүүдэд болон ажлын хэсгийн гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд ирцийг танилцуулъя. Ренчиндоржийн Батболд, Загджавын Мэндсайхан, Даваагийн Цогтбаатар, Жигжилийн Батжаргал, Чинбатын Номин, Батжаргалын Заяабал, Даваахүүгийн Пүрэвдаваа нарын гишүүд хүрэлцэн ирж ирц 58.3 хувьтай байна аа.

Төсвийн зарлагын хяналтын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж дэд хорооны ирц 58.3 хувьтай бүрдсэн тул Төсвийн зарлагын хяналтын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Дэд хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

2026 оны Монгол Улсын төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлэг. Санал дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна Хэлэлцэх асуудалдаа орлоо. Санал гарсан гишүүд алга байна аа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Лангааны Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Занабазарын Цэнджав Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитийн газрын захирал, тэргүүлэх аудитор, Буяндэлгэрийн Баттуяа Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний Аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Идшийн Батхүү Эдийн засаг хөгжлийн яамны ТНБД, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Сэрээнэндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг хөгжлийн яамны Макро

эдийн засгийн бодлогын газрын дарга, Төмрийн Баясгалан Эдийн засгийн хөгжлийн яамны Төр хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Батболдын Мөнхтөр Эдийн засгийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Төсвийн судалгааны газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засгийн хөгжлийн яамны Тогтвортой хөгжил нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Баяраагийн Урьболд Эдийн засаг хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Жаргалсайханы Гэрэлбат Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Шаравын Бат-Эрдэнэ Сангийн яамны хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага арга зүйн газрын дарга, Сангидоржийн Баярмаа ГЕГ-ын Татварын орлогын газрын дарга, Б.Номин Эдийн засгийн хөгжлийн яамны Төслийн хөрөнгө оруулалт, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна аа.

Жавхлан сайдыг урьж байна.

Жавхлан сайд орчихсон. Сангийн сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулж 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, ирэх 2026 оны төсвийн төслийг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөтэй уялдуулан боловсрууллаа. Төсвийн төсөлд туссан онцлох арга хэмжээг дурдвал 1 дүгээрт төсвийн урсгал зардлын хувьд удирдах албан тушаалтны орон тоог бууруулж төрийн албан хаагчдын нийт орон тооны тэлэлтийг хязгаарлахын зэрэгцээ төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийн байгууллагын үр ашиггүй зардлыг бууруулан хэмнэгдсэн хөрөнгийг нийгмийн салбарт зарцуулахаар улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдсэнтэй холбоотойгоор ЭМД-ын тухай хуульд заасан улсын төсвөөс шимтгэлийг нь хариуцах иргэдийн шимтгэлд зориулж 79 тэрбум төгрөгийг нэмэгдүүлэхээр Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын 17 дугаар бага хурлыг 2026 онд Монгол Улсад зохион байгуулах болсонтой холбогдуулан хурлын бэлтгэл ажлыг хангах улс орноо сурталчлан таниулах, мэдээлэл түгээх, дамжуулах, соёл урлагийн арга хэмжээ зохиох, олон улсын зочид, төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах 5 тухтай орчныг бүрдүүлэх зэрэг арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэхээр геологийн салбарыг уул уурхайн

салбараас түрүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтыг татах, тааламжтай орчныг бүрдүүлэх, геологи, эрдэс баялгийн судалгааны ажлыг дэвшилтэт техник, технологиор гүйцэтгэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг 2025 онтой харьцуулахад 30 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилгоор 2023-аас 2028 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулж тус салбарын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор хөнгөлөлттэй зээл олгохоор Засгийн газрын 2025-аас 2055 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн.

Тогтоолын хүрээнд 4 улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх аялал жуулчлалын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх чиглэлээр аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулж 6 хувийн хүүтэй 6 хүртэлх жилийн хугацаатай нийт 267 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2026 онд олгохоор тооцоолж зээлийн хүүгийн дэмжлэгт зориулж 23.1 тэрбум төгрөгөөр хариуцан төлөхөөр, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт уламжлалт мал аж ахуй болон эрчимжсэн ХАА боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжиж дотоодын хэрэгцээгээ Монголын хөрсөнд ургасан эрүүл хүнсээр бүрэн хангахаар тусгагдсан. Энэ хүрээнд эрүүл хүнс үйлдвэрлэгч экспортлогч бүс болох зорилтыг дэвшүүлж, Хүнсний хангамж, аюулгүй байдал, Шинэ хоршоо, Чинээлэг малчин, Цагаан алт, Атар-4 үндэсний хэмжээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ХАА-н салбарт хөнгөлөлттэй зээлийг олгож төрөөс зээлийн хүүгийн дэмжлэг олгохоор 2026 онд төсвийн төсөлд тусгалаа.

Хоёрдугаарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хуульд заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн иргэдээс санал авч, сум, дүүрэг, аймаг, нийслэл, салбар яамны түвшинд үе шаттайгаар төлөвлөсөн Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр нийт 14.4 их наяд төгрөгийг санхүүжих дүн бүхий 1712 төслийн санал хүлээн авснаас холбогдох шалгуур үзүүлэлт, зарчим, бодлогыг харгалзан эрэмбэлж 579 төсөл арга хэмжээнд 3 их наяд 267.3 тэрбум төгрөгийг хэрэгжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан болно оо.

Нийт хөрөнгө оруулалтын 67 хувь буюу 2 их наяд 181.9 тэрбум төгрөг нь үргэлжлэн хэрэгжих бол 33 хувь буюу 1 их наяд 85.5 тэрбум төгрөг нь шинээр хэрэгжих хөрөнгө оруулалт байна аа. Энэ нь 2022-2023 онд батлагдсан төсвийн тоотой харьцуулахад 2 дахин буурсан үзүүлэлт бөгөөд төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх шалгуур үзүүлэлтийн чанар сайжирч байгааг илтгэж байна аа. Түүнчлэн 2026 онд төсвийн хөрөнгө оруулалтад хүний хөгжлийг дэмжих зорилгоор боловсрол эрүүл мэндийн салбарт урьдчилсан хөгжил болон хувийн хэвшлийг дэмжиж бизнесийн орчныг сайжруулах хүрээнд эрчим хүч, суурь, дэд бүтцийн салбарт гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор онцгой байдлын салбарт нийгмийн хэв журам аюулгүй байдлыг хангах үүднээс батлан хамгаалах харилцаа, гадаад харилцаа, ХЗДХ-ийн салбарт шинэ хөрөнгө оруулалтыг түлхүү төлөвлөлөө.

Мөн олон улсын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд НҮБ-ын Коп-17 хурлыг зохион байгуулахад шаардлагатай санхүүжилт болон гадаад зээл, тусламжийн төслүүдийн Монголын талын хариуцах хөрөнгийг төсөвт тусгасан.

Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 31.6 их наяд төгрөг нэгдсэн төсвийн суурь зарлага 29.6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 2 их наяд төгрөгийн ашигтай буюу ДНБ-ий 2 хувь байж төсвийн тусгай шаардлагуудыг бүрэн хангахаар байна аа.

Иймд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Да.Цогтбаатар: Танилцуулга хийсэн Сангийн сайд Болдын Жавхлан сайдад баярлалаа.

Хууль санаачлагч болон Монгол Улсын Үндэсний аудитын газраас асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Асуулт ингээд болчихсон уу? Пүрэвдаваа гишүүнээр тасаллаа. Би өөрөө араас нь асуулт асууна аа. Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье.

Д.Пүрэвдаваа: Та бүхэндээ энэ өдөр өглөөний мэндийг хүргэе. Сүүлийн өдрүүдэд энэ багш эмч нарын цалингийн асуудал яригдаж байгаа. Ялангуяа Эдийн засаг, хөгжлийн яамнаас тодруулж асуумаар байна. Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд миний санаж байгаагаар энэ Засгийн газрын шийдвэр ил тод байх ёстой. Дээрээс нь тэмдэглэл ил тод байх ёстой гэсэн хуулийн заалт байгаа гэж ойлгодог. Тэр мэдээллийг олж авах иргэдэд тэр нээлттэй байх тал дээрээ ямар ажил зохион байгуулсан бэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ багш нарын цалин хэдэн сарын хэднээс ямар үе шатлалтай, ямар хэм хэмжээгээр буюу журмаар шийдвэрлэгдэж байгаа вэ? Тэгээд ирэх жилийн дунд хугацаандаа багш нарын цалин нийт төсвийнхөө хэдэн хувийг нь эзлэхээр та нар эдийн засгийн тооцоолол хийсэн бэ? Үүнтэй зэрэгцээд юу үүсэж байна вэ гэхээр зэрэг эмч, эмнэлгийн ажилтнуудын асуудал үүсэж байгаа юм. Одоогийн нөхцөл байдлаар эмнэлгийн чиглэлд зарцуулагдаж байгаа төсөв нийт төсвийн хэдэн хувийг нь эзэлж байгаа юм. Дунд хугацаандаа хэдэн хувийг нь эзлүүлэхээр та бүхэн маань төсөөлж байгаа юм.

Одоо нийт төрийн албан хаагчдыг 230 мянга байна гэж бодоход багш, эмч нар, тэдгээрийн байгууллагад ажиллаж байгаа нөхдүүд ер нь бараг 100000-ыг нь бүрдүүлж байгаа байх гэж ойлгож байна. Тэгэхээр энэн дээр ойрын болон дунд хугацааны бодлого тэрэн дээр гаргасан Засгийн газрын сүүлийн 2 хуралдааны шийдвэр тэрийгээ маш тодорхой илэрхийлээч тэгээд тодруулъя.

Да.Цогтбаатар: Эдийн засгийн хөгжлийн яамнаас 3 номер. ТНБД.

И.Батхүү: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын гаргасан мэдээллийг, гаргасан шийдвэрийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тодруулаад танд холбогдох мэдээллийг нь хүргүүлье ээ.

Төсвийн задаргаатай холбоотой асуудал блд Сангийн яаман дээр тооцоолол хуваарилалт нь хийгдэж явдаг. Сангийн яамнаас нэмэлт мэдээлэл өгөх байх. Эдийн засаг хөгжлийн яамны хувьд бол макро эдийн засгийн дунд хугацааны тооцоолол дээр 3 жилийн төсвийн хүрээний мэдэгдэл төсөөлөл дээрээ урсгал зардлын ангиллаа бууруулах. Ер нь төсөвт эзэлж байгаа урсгал зардлын ангилал ойрын жилүүдэд хэт өндөр өссөн байсныг жишээлбэл 2026 онд 24 хувьд барих ч гэдэг юм уу. Макро эдийн засгийн инфляц үзүүлэх нөлөөллөөр бусад төсвийн зардлын оновчтой бүтэц гээд олон улсад манай Монголын судлаачдын хийсэн судалгаа, дүгнэлт, санал зөвлөмжүүдтэй нийцүүлээд эдийн засгийн зөв бүтэцтэй болох талаас нь бодлогын чиглэлүүдээ гаргасан байгаа.

Тэгэхээр ирэх жилүүдэд энэ төсвийн зардлын дотоод задаргаан дээр төсвийн бодлогын хүрээнд Сангийн яамнаас тодорхой хуваарилалтууд нь хийгдээд явах байх гэж ойлгож байгаа. Ерөнхий бодлогын чиглэл нь бол ДНБ-д эзлэх төсвийн орлого зарлагын хэмжээг үе шаттайгаар бууруулах, эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах. Бизнес хувийн хэвшлийг дэмжсэн төсвийн бодлогыг дунд хугацаандаа хэрэгжүүлэх. Үүнийгээ дэмжсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх. Тухайлбал Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Зөвшөөрөл мэдэгдлийн тухай хууль гээд энэ эрх зүйн орчныг нь сайжруулах талаар ажиллах бодлогын чиглэлүүд гаргаад ажиллаж байгаа.

Сангийн яамнаас саяын задаргааг нь хэлье.

Да.Цогтбаатар: Сангийн яамнаас 5 номер Санжаа дарга.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Пүрэвдаваа гишүүний асуултад хариулья.

Төсвийн төслийг Засгийн газраас өргөн барихдаа бол бид төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй байхаар оруулж ирсэн. Төсөв өргөн барьсны дараа нөхцөл байдал арай өөрчлөгдөөд тэгээд боловсролын салбарын үйлдвэрчнийхэнтэй Засгийн газр-ын зүгээс хэлэлцээ эхэлж хийж эхэлсэн байдаг. Тэгээд ямар ч байсан хэлэлцээний үр дүнд ирэх оны 1 сарын 1-нээс багш нарын цалинг тодорхой хэмжээгээр нэмээд тэгээд дахиад жилийн дундуур эсвэл жилийн сүүлээр дахиж нэмэхээр ийм хэлэлцээрт хүрч байгаа гэж ойлгосон.

Гэхдээ нөгөө талдаа мэдээж хэрэг энэ маань өөрөө эх үүсвэрээрээ хязгаарлагдаж шийдэгдэх ёстой.

Тэгэхлээр ажлын хэсэг дээр бол энэ дээр шаардлагатай эх үүсвэрийн хэмжээг тодорхойлж гаргахаар ажиллаж байгаа Төсвийн байнгын хорооны 3 дугаар хэлэлцүүлэг орохоор энэ дээр гарч ирнэ гэсэн. Бид нар хүлээлттэй байгаа. Харин эмнэлгийн ажилчдын хувьд бол 11 сарын 13-аас мөн ажил хаяхаар ийм мэдээлэл бол гарсан байна лээ. Засгийн газрын хувьд бол өнөөдөр Засгийн газрын хуралдаанаар бол 2027 оныг бол эрүүл мэндийн салбарын жил болгон зарлаж байгаа. Үүнтэй холбоотойгоор бид нар ер нь боловсролын салбартаа бол мэдээж хэрэг төсвийн бололцоо маань хэмжээ хязгаартай учраас 2026 онд боловсролын салбартаа түлхүү анхаараад 2027 онд эрүүл мэндийн салбартаа түлхүү анхаараад ингээд явъя гэдэг байдлаар цалингийн бодлогын хувьд явж байгаа. Баярлалаа.

Хэлэлцүүлгийн хувьд бол хэлэлцүүлгийг энэ жилд нэлээд өргөн байдлаар хийсэн. Хоёр янзаар Засгийн газр-ын түвшинд хийсэн байгаа. Нэг нь танхимаар, нөгөөх нь И Монголиа аппликэйшнаар хийсэн байгаа. мөн төсөв 9 сарын 1-нд өргөн барьсны дараа бол Төсвийн байнгын хороо 7 сэдвээр салбараар гэх үү дээ хэлэлцүүлгийг хийсэн байгаа. Үүн дээр давхардсан доогуур үзэх юм бол 200 гаруй мянган хүн хамрагдаж санал хүсэлтээ тодорхой хэмжээнд өгч оролцсон ийм үр дүнтэй гарсан байгаа. Баярлалаа.

Да.Цогтбаатар: Пүрэвдаваа гишүүн тодруулга. Нэг мөсөн 2 минутаар юм уу. Пүрэвдаваа гишүүнд нэг минут.

Д.Пүрэвдаваа: Ингээд байхгүй юу даа. Эдийн засгийн хөгжлийн яамаа 2026 оны төсөв чинь бол сүүлийн бараг 9 сарын 1-нд өргөн баригдсанаас хойш сар гаруй яригдаад энийг чинь бүх зүйлийг хэчнээн ч удаагийн хурлаар ярьчхав. Тэгээд ойлгомжтой зүйл байна. Багш эмч нарын тодорхой тэр нэг 800 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэрийг гаргаж авахын тулд ажлын хэсэг Ганхуяг даргаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаад нэг урсгал зардал болон шинэ хөрөнгө оруулалтаасаа хасаад тэгээд энэ нэг жилдээ бол торгоож байгаа л гэж ойлгож байгаа шүү дээ. Тэгээд би мэдэхгүй тоотой холбоотой юм асуухаараа Сангийн яам руугаа шидчихдэг. Дараа жил дахиж ийм асуудал үүсэхгүй байх нөхцөлийг яаж хангаж байгаа юм. Дунд хугацаандаа яаж хангаж байгаа юм.

Дээрээс нь багш нар ингээд болчихдог юм байна. Эмч нар чинь 13-нд хаяхад.

Да.Цогтбаатар: Пүрэвдаваа гишүүнд нэг минут.

Д.Пүрэвдаваа: Эмч нарын асуудал үүснэ. Ер нь энэ төрийн алба хашиж байгаа, дундаж цалингаас доогуур цалин авч байгаа тэр төрийн албан хаагчдын ер нь тоо хэмжээ энэ судалгааг миний ойлгож байгаагаар Эдийн засгийн хөгжлийн яам л төсөөлж боох ёстой гэж хараад байгаа шүү дээ. Тэгж байж тэр төсвийн хүрээ тэр тооцооллоо гаргах ёстой гэж хараад байгаа шүү дээ. Зөвхөн эмч багш нарын хажуугаар миний мэдэхээр бол энэ дүүрэг суманд ажилладаг төрийн албан хаагчдын цалин бол маш бага байдаг. Дараа нь тэд нар ажлаа хийх үү? Тэгээд л онцгой байдал янз янзын төрийн хүнд хүчир ажил хийдэг нөхдүүд дахиад л ээлжлээд л ажлаа хаях уу? Тэгээд энэ бодлогоо та бүхэн маань ил тод нийтэд ил гаргах ёстой байтал тэгээд нэг тоо ярихгүй хүүрнэсэн өгүүлбэрээр нэг ийм юм яриад байх юм. Жоохон тооцоололтой юм ярья.

Да.Цогтбаатар: 3 номер Эдийн засгийн хөгжлийн яамны ТНБД Батхүү.

И.Батхүү: Пүрэвдаваа гишүүний энэ төсвийн хүрээний мэдэгдлийн 9 тоо макро эдийн засгийн тоонууд байгаа. Энэ тоонуудын цаашдаа гаргахдаа төсөөллийг нь хийхдээ салбар салбарын салбарын өсөлтийн боломж, гадаад дотоод нөхцөл бусад загваруудаа ашиглаад хийж байгаа юм. Энэ тоондоо нийцүүлээд тухайн жилийн төсөв, ялангуяа урсгал зардлын төсвийг боохдоо Сангийн яам хууль тогтоомжоороо хийдэг зохицуулалттай. Улсын Их Хурал дээр энийг хэлэлцэж баталдаг. Яг миний ойлгосноор өргөн барьсан төсвийг Засгийн газар тэр дунд дундаа аль нэг яам тооцооллыг нь өөрчлөх асуудал хийх боломжгүй гэж ойлгож байгаа. Ер нь бол зарчмын хувьд инфляцтай нийцүүлээд ер нь цалингийн хэмжээг өсгөөд явж байх нь зүйтэй гэж ойлгож байгаа.

Да.Цогтбаатар: Пүрэвдаваа гишүүн уг нь нөгөө бодлогыг нь та нар яаж зангидах юм бэ л гэж асуугаад байх юм. Тэгээд та нар болохоор Сангийн яам тооцооллыг нь хийгээд ороод ирэхээр нь бодлогоо өөрчилдөг гэж хариулах гээд байх шиг байгаа юм. Сангийн сайд нэмэлт хариулт.

Б.Жавхлан: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя.

Засгийн газар хугацаандаа буюу 9 сарын 1-нд төсөв өргөн барьсан. Төсөв дотор 2026 оны цалингийн бодлого ч багтчихсан явж байгаа. Цалингийн бодлого юу байх вэ ер нь төсвийн хязгаартаа баригдаж бид нар ирэх жил, цалингийн, төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл боломжгүй ээ. Тэтгэвэр, тэтгэмжийн хувьд бол хуулийн тогтоолын заалттай байдаг учраас инфляцтай уялдуулж тодорхой хувь хэмжээ буюу 6 хувиар нэмэгдүүлэе гэдэг Засгийн газрын бодлогоо өргөн барьсан. Төсвөө Улсын Их Хуралд өргөн барьсан. Төсөв Улсын Их Хурлаар батлагдтал энэ хооронд бол Засгийн газар хүлээгээд л байж байхаас өөр арга байхгүй шүү дээ. Энэ хооронд бид нар бодлогоо өөрчилнө гэж байхгүй. Энэ хооронд тодорхой салбарын ажил хаялт мөн энэ шаардлагууд ирсэн. Сая энэ Улсын Их Хурал дээрээс ажлын хэсэгт Байнгын хороодоос энэнтэй холбоотой тооцоолол хийж.

Да.Цогтбаатар: Сангийн сайдад нэмэлт минут.

Б.Жавхлан: Ингээд өр нэгэнт өргөн барьсан төсөв дотор юу гэдэг юм илүү гарсан орон зай төсвийн орон зай гэдэг ойлголт огт байхгүй. Засгийн газар үйл ажиллагааны төлөвлөгөөнөөсөө л татна. Ирэх жил хүрэх олон салбарын зорилтуудаасаа л 10, 10 хувь татаж тэрэнд шаардлагатай байсан санхүүжилтүүдийг хассанаар энэ цалингийн нэмэгдэл байж болох юм гэдэг ийм тооцооллыг хүргүүлсэн байгаа. Мөн ямар Улсын Их Хурал энэ салбаруудтай хэлэлцээрт орно гэж байхгүй шүү дээ. Ингээд ямар ч байсан Засгийн газар ороод хэлэлцээрт ороод бид төсөв өргөн барьсан хойноос нь ийм тооцооллыг хүргүүлж байна гэдгийгээ салбаруудад дуулгасан байгаа. Тэрнээс биш одоо энэтэй холбоотой цалингийн бодлого Засгийн газар дээр шууд өөрчлөгдөөд явах ийм боломж байхгүй шүү дээ. Ямар ч байсан төсөв ингээд батлагдаад гараад ирнэ.

Ингээд төсвийн дагуу л бид зарцуулалтаа хийгээд өөрчлөлтүүдээ хийгээд.

Да.Цогтбаатар: Сангийн сайдын тайлбарыг ойлгож байна. Зүгээр Эдийн засгийн хөгжлийн яаман дээрээс бодлогоо яаж зангидах юм бэ гэдэг юмыг л асуухаар хариулт нь тооцооллоороо гарч ирж байна гэдэг юм яригдаад байна. Зөв биз дээ? Сангийн сайд гүйцээгээд хариулчихъя.

Б.Жавхлан: Ер нь бол ингэж байгаа юм. Бид урагшаагаа ярих хэрэгтэй. 2020, 2021 оны ковидоос үүссэн үнийн өсөлтийн давллагаа цалингаа хөөж гүйцэхгүй явсаар байгаад 2023, 2024 оныг хүртэл 4 жилийн циклд арайхийж хөөж гүйцсэн юм. Тэр 2020, 2021 оны ковидын тэр инфляц тэр 16, 17 хувь хүрсэн чинь бүтээгдэхүүн рүүгээ шингээд түрүүлж шингээд арайхийж хойноос нь цалингуудыг нэмээд тэтгэврүүдээ нэмээд хөөж гүйцээд ингээд инфляц ингээд дөнгөж бууж ирж байсан эхний давллагаа. Ингээд салбарыг нь сугалаад энэ чинь аягүй өндөр хувиар ингээд нэмчихээр инфляцад хүчтэй нөлөөлнө. Бусад салбарууд ч гэсэн таны ярьж байгаа шиг ийм барьцнаа. Маш их төсөв дээр ийм дарамтууд ирнэ. Дөнгөж ингээд нэг давллагаа даваад инфляц нь бууж байтал ингээд цалин нэмэгдчихээр өөрөөр хэлбэл

бүтээмж нэмэгдээгүй байхад цалин нэмэгдчихээр аягүй аюултай инфляцад шууд нөлөөлнө, эрэлтийн инфляцад нөлөөлнө.

Дээрээс нь хамгийн хүчтэй нөлөөлдөг юм нь хувийн секторт хувийн секторынх нь.

Да.Цогтбаатар: Асуулт асууж, хариулт авч дууслаа. Дэгийнхээ хуулиар нөгөө асуулт хариултын чинь хугацаа дуусчихлаа. Нэмэлтээр би нэг асуултууд асуугаадахъя аа. Энэ жилийн 2026 оны төсвийн төслийг өргөн барихдаа 5 үе шаттайгаар болгож байгаад салбар болгоны хэлэлцүүлгийг хийж төслөө ярилцсан. Энэ дээрээс миний хувьд хараад байгаа юм жишээлэхэд багш нарын цалингийн нэмэгдлийг тооцоолж орж ирж чадаагүй.

Эрүүл мэндийн салбарын ажилчдын цалингийн нэмэгдлийг тооцоолж орж ирж чадаагүй. Яг энэ хэлэлцүүлэг дээр ямар үр дүн гарсан болоод яг энэ хэлэлцүүлгүүдийг амжилттай зохион байгуулчихсан гэж үзэж байгаа вэ гэдэг нэг асуулт байна.

Хоёр дахь асуудал нь энэ нийслэлийн зүгээс энэ шаардлагагүй явган зам бордюрыг маш ихээр зүгээр байгаа замыг эвдэж байгаад буцаагаад шинээр хийгээд байгаа юм. Энэ мэт ийм үрэлгэн зардлуудаа яавал больж чадах юм бэ гэдэг нэг ийм асуулт байгаад байгаа юм. Тэгээд энэ төр хувийн хэвшлийн түншлэл дээр ТЭЗҮ шаардлагагүй явна гэж нэг ийм ойлголт байгаад байх шиг байгаа юм. ТЭЗҮ шаардлагагүй явна гэхээр чинь одоо бид нар энэ Төсвийн тухай хууль батлахдаа хөрөнгө оруулалтуудыг хийхдээ заавал ТЭЗҮ зураг төсөв магадлангаар батлагдсан байх ёстой гэдэг шаар дадлага тавиад байтал төр хувийн хэвшлийн түншлэл дээр зураг төсөв магадлангүйгээр юмнууд явна гэдэг ойлголт байж болохгүй байх. Энэ дээр нэг тайлбар хэлээч гэсэн нэг ийм асуултууд байна. Тэгээд энэ хариултаа авчхаад нэг тодруулъя даа. Хариулт хэн өгөх вэ? 4 номер Төр хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Баясгалан.

Т.Баясгалан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Цогтбаатар гишүүн ээ Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх гэж байгаа бүх төслүүд ТЭЗҮ үгүй явна гэсэн ойлголт байхгүй юм аа. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд төрийн үйлчилгээний зарим төслүүд ТЭЗҮ шаардахгүй байж болно оо гэдэг байдлаар томьёолж байгаа. Төслийнхөө онцлогоос хамаараад ТЭЗҮ шаардаж ч болохоор зохицуулалт орж ирж байгаа шүү. Энийг огт шаардахгүй гэсэн агуулгаар тусгаагүй. Өөрөөр хэлбэл зарим төрийн үйлчилгээний төслүүд дээр заавал ТЭЗҮ шаардах нь өөрөө төслийн процессыг удаашруулах процесс ажиллагаа сунжрах ийм хандлагатай байгаа учраас зарим жишээлбэл, хуульд заасан түншлэлээр хэрэгжүүлэх гэрээнийхээ төрлөөс хамаараад энэ нийтийн зориулалттай дэд бүтцийн төслүүд дээр заавал ТЭЗҮ-тэй байна. Төрийн үйлчилгээний зарим төслүүд дээр төслийнхөө онцлогоос хамаараад цар хүрээнээсээ хамаараад хэрэгжих хугацаа бүх энэ урьдчилсан үнэлгээ болон бүрэн шинжилгээний шатад гарч ирсэн энэ дүгнэлтийнхээ тайлангаас хамаараад ТЭЗҮ шаардахгүй байх энэ юмыг нь байж болохоор зааж өгч байгаа. Тэрнээс бүгд байхгүй гэсэн ийм зохицуулалт ороогүй байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Да.Цогтбаатар: Үрлэгэн зардалтай холбоотойгоор аудит хариулах уу? Нэг номер.

3.Цэдэнжав: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Төрийн аудитын байгууллагаас төсвийн орлогыг нэмэгдүүлэх зардлыг бууруулах боломжийг аудитын дүгнэлтээр гаргаж өгсөн байгаа. Таны асуулттай холбоотой тэр нийслэлийн авто зам бордюртай холбоотой асуудлаар манай нийслэл дэх Төрийн аудитын газраас гүйцэтгэлийн аудит хийгээд дуусаж байгаа. Аудитын тайлангаа Төсвийн байнгын хороонд хүргүүлж хэлэлцүүлнэ ээ.

Да.Цогтбаатар: Би тэгээд эргээд нэг танд нэг коммент хэлье. Сангийн сайдаас нэг асуулт асуугаадахъя. Геологи уул уурхайн салбарт хайгуул хийх зорилгоор 30 тэрбум төгрөг гээд түрүүн танилцуулгадаа Сангийн сайд ярьчихсан. Ер нь бол 2026 онд хэдэн тонн алт олборлоно гэдэг тооцоололтой байгаа вэ гэдэг нэг ийм асуулт байна. Эдийн засгийн хөгжлийн яамнаас нэг асуулт байна. Түрүүн сая Пүрэвдагва гишүүн асуултдаа асуусан. Хариулт дээр нь улсын төсөв дээр урсгал зардлын хэмжээ сүүлийн жилүүдэд тогтмол өсөж байгаа гэдэг нэг тайлбар хэлсэн. Энийгээ яг ямар ямар онуудад хэдэн төгрөгөөр өсчихсөн байгаа вэ? Энийг нэг дэлгэрүүлж яриач.

Аудит бол наанаа орж ирж асуултад хариулахдаа уг нь гүйцэд мэдээлэлтэй орж ирээд суувал зүгээр байгаа юм. 2025 онд хийгдсэн ажлууд, 2024 онд хийгдчихсэн үр дүнгүй ажлуудыг бүгдээрэнг нь хариулаадах гэхээр та надаа өмнө нь ч нэг хурал дээр яг ийм нөхцөл байдал гарсан. Сая ч гэсэн яг нэг бичгээр өгнө. Эсвэл дараагийн хурал дээр танилцуулна гээд байгаа юм. Хариулт байхгүй юм бол наанаа суух шаардлага байхгүй шүү дээ. Хариулж чадахгүй байна гэдгээ үнэнээр нь хэлэх хэрэгтэй. Тэгээд хариулахын тулд та нар ажил хийгээд байгаа шүү дээ. Хариуцлагатай байх ёстой гэж бодоод байна. Хариулт авъя. Сангийн сайд.

Б.Жавхлан: Уг нь сайд нь байсан их оновчтой хариулах байх шүү. Би сайдын өмнөөс буруу дутуу зөрүү юм ярьчих вий. Уул уурхайн бодлого сүүлийн жилүүдэд ер нь энэ хайгуул талдаа нэлээн алдагдсанаас үйлдвэрлэл маань цар хүрээтэйгээр, өргөн цар хүрээтэйгээр тэлж чадахгүй байгаад байгаа нэг ийм цаг хугацааны хайчинд бид ирсэн гэж хараад байгаа. Өөрөөр хэлбэл яах вэ улс бол яг хайгуулын түвшин биш юм шиг байгаа юм аа. Мэргэжлийн хэллэгээрээ юу гэдэг юм? Энэ чинь нөгөө тандан судалгаа шүү дээ агаараас тиймээ. Эрэл судалгаа билүү тиймээ? Эрэл судалгаа буюу энэ тандан судалгаа. Энэний дараа хувийн ААН-үүд бол газар дээр нь нарийвчилсан ийм хайгуул хийдэг юм байна. Ийм технологитой явдаг болсон байна лээ. Энэ нь одоо сүүлийн үеийн технологи. Илүү их үр дүнтэй гэж байгаа юм. Тийм учраас харин ч энэ дүн нь нэлээн багадаж байна аа.

Да.Цогтбаатар: Сангийн сайд нэмэлт хариулъя.

Б.Жавхлан: Санал нь бараг 100 гаруй тэрбум төгрөг ирсэн юм. Тэгээд зардаг ер нь бараг хориод яамтай олдог. 1, 2 яамтай гэж манай уул уурхайн сайд маань ярьдаг. Энэ тавьсан мөнгө маань ч хангалтгүй хүрэлцээгүй байгаа гэсэн ийм л салбар салбар дээр байгаа дүнгүүд маань ийм байгаа. Тэр алт олборлох хэмжээ энэ юмыг яамнаас нь хариулах уу?

Да.Цогтбаатар: Эдийн засгийн хөгжлийн яам 3 номер Батхүү дарга.

И.Батхүү: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя аа.

Түрүүн Пүрэвдаваа гишүүн асуухдаа төсвийн дотроос асуугаад байсан болохоор манай яаманд тэр тоо нь чиг үүргийн хувьд хариуцдаггүй учраас тэгж хэлсэн юм. Манай яамнаас хариуцаж боловсруулсан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөн дээр яг энэ талаар баримталж байгаа бодлогынх нь заалтыг нь би хэлж өгье. 2026 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2.1.18 дээр багш ажилчдын цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлыг тэргүүн ээлжид сайжруулна. 2.3.9 дээр.

Да.Цогтбаатар: Батхүү даргаа түрүүн таны хариултад сүүлийн жилүүдэд урсгал зардал дотор эзэлж байгаа урсгал зардал өсөөд байна. Тэрэн дотор эзэлж байгаа цалингийн зардлууд өсөөд байна гэдэг тооцоолол та өөрөө ярьсан учраас л тооцооллыг нь танаас асуугаад байгаа юм. Тэрнээс онолын шинж чанартай юмнуудыг орхичихье.

И.Батхүү: Одоо надад байгаа тоогоор 2018-аас 2025 он хүртэл урсгал зардлын ДНБ-ий эзлэх хувь хэмжээ, тэр дундаа цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын өсөлтийн хувь хэмжээнүүд байж байгаа. Энэ тоо хүснэгтээр байгааг Байнгын хорооны даргад хүргүүлэх үү?

Нэгдүгээрт нь 2018 оны гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын хэмжээ бол ДНБ-ий эзлэх хувь нь 5.8 байсан. 2029 онд 6 хувь, 20 оны гүйцэтгэлээр 7.1 хувь, 21 оны гүйцэтгэлээр 5.8 хувь, 2022 оны гүйцэтгэлээр 3.1 хувь, 2023 оны гүйцэтгэлээр 3.3 хувь болсон бол 2024 онд 6.7 хувь болж өссөн байна. 2025 оны гүйцэтгэлээр 7.1 хувь болж өсөхөөр хүлээлттэй байна.

Да.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа. Би төгсгөлд нь нэг үг энэ Сангийн яам руу гэх юм уу Засгийн газар руу хандуулаад хэлэх гэсэн юм. Сая бид нар цалингийн нэмэгдлийн асуудлаар багш нартай нэг харилцан ойлголцолд хүрээд төсөв маань ажлын хэсэг дээрээ нэлээн сайн хуралдаад цаашаа явах гэж байх шиг байна. Тэгтэл нөгөө эмнэлгийн эмч ажилчдынх нь зүгээс цалингийн нэмэгдлийг хийхгүй бол ажил хаялт зарлана гээд жишээлэхэд яг миний гарт энэ Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны бичиг ирчихсэн байна.

Баянхонгор аймгийн Магсарын нэрэмжит нэгдсэн эмнэлгийн үйлдвэрчний хорооны бичиг ирсэн байна. Эд нар дээр бичиж байгаа энэ агуулгуудыг нь харахаар яах вэ багш нарын ажил хаялт бол хүүхдийн хичээлийн хоцрогдол буюу хүүхдийн сурч боловсрох эрхтэй холбоотойгоор нэг жоохон доголдол үүснэ гэж эмч нарын зүгээс харж байна. Эмч нар ажил хаялт хийхэд бол хүний эрүүл мэнд амь настай холбоотой асуудлууд яригддаг учраас өргөсөн тангарагтаа үнэнчээр тэвчээртэйгээр хүлээж байна аа. Тэгтэл ажил хаяж чадсан багш нар нь 50 хувь, 76 хувь гэдэг тоо яригддаг. Одоо нэмчих байлгүй дээ гэдэг итгэл үнэмшлээр хүлээж байсан эмч нарын цалин нэмэгдэж чадахгүй байгаа дээр тодорхой байр суурийг асууж өгөөч ээ. Тэгээд энэ дээр үндэслээд дараа дараагийнхаа арга хэмжээг авна шүү гэдэг утгатай ийм үйлдвэрчний эвлэлүүдийн бичиг ирээд байгаа учраас Сангийн сайдаас энэ дээр нэг тодруулга авъя. Эрүүл мэндийн эмч ажилчдын цалингийн нэмэгдлийн талаар Засгийн газрын барьж байгаа бодлогын талаар та нэг мэдээлэл өгөөч. Сангийн сайд.

Б.Жавхлан: Дэд хороон даргын асуултад хариулъя.

Өчигдөр уржигдар болсон хэлэлцээрийн дэлгэрэнгүй мэдээллийг аваагүй байна. Сая яг салбарын сайд нар Засгийн газрын хуралдаан дээр мэдээлэл хийх байлаа. Би сая дуудагдаад ороод ирсэн учраас хараахан мэдээлэл аваагүй байна шүү. Ер нь бол бид энэ цалингийн түвшин цалингийн 2026 онд баримтлах бодлогуудаа 9 сарын 1-нд өргөн барьчихсан шүү дээ. Өргөн барьчихсан. Өргөн барьснаас хойш энэ асуудлууд гарч ирээд хэлэлцээр хийгдээд явж байгаа учраас энэ их төвөгтэй байдал үүсээд байгаа юм.

2026 онд баримтлах цалингийн бодлого гэж ярихад одоогоор арай эрт байна. Ер нь энэ эрүүл мэндийн салбар боловсролын салбар 2 маань нийгмийн хамгийн том 2 манай салбар байдаг. Гэхдээ энэ цалингийн бүтэц тооцоолол систем нь бол арай жоохон өөр.

Да.Цогтбаатар: Нэмээд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: 9 сарын 1-нд өргөн барьсан төсвөөр буюу одоогийн байгаа цалингийн бүтцээр бол эрүүл мэндийн салбар маань боловсролын салбараас арай урд нь явж байдаг.

Дээрээс нь эрүүл мэндийн салбар маань боловсролын салбараас арай түрүүлж нэг жилийн өмнө гүйцэтгэлд суурилсан энэ санхүүжилт цалингийн систем рүү орсон. Дээрээс нь энэ нөгөө ЭМД-ын сангаас яг тарифаараа өдөр тутмын үйлчилгээний тарифаараа цалинжаад, гүйцэтгэлээрээ аваад явдаг учраас боловсролын салбараас арай өөр. Боловсролын салбар мөн гүйцэтгэлд суурилсан цалингийн систем рүү орсон. Гэхдээ өдөр тутмын тарифаар явдаг энэ эрүүл мэндийн салбараас тогтолцоо нь шал өөр 2 салбар байхгүй юу.

Тэгэхээр одоо нэгж цалин дээр нь тэдэн хувь нэмэх гэдгээс илүүтэйгээр гүйцэтгэлд суурилсан цалингийн сан дээр тэдэн хувиар нэмэгдэнэ. Энүүгээрээ тэгээд яг гүйцэтгэл, хэдэн удаагийн тариф, хэдэн удаагийн үйлчилгээ үзүүлсэн байна. Ингээд цалин нь өсөөд явдаг ийм л зарчим руугаа шилжиж байгаа зүйл.

Да.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.14-д заасан хугацаанд ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна аа.

Аудитын дүгнэлтийн 1 дүгээр хавсралтад дурдсан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялаагүй нийт 76929.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хасаж алдагдлыг бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Санал хураалт.

Санал хураалтад 7 гишүүн оролцож, 7 гишүүн татгалзаж энэ санал дэмжигдсэнгүй ээ.

1.Багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор дараах төсөл, арга хэмжээг төслөөс хасаж, хөрөнгийн зардлыг нийт 126,293.4 сая төгрөгөөр бууруулах. Үүнд:

1.1.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүн **40,000.0 сая** төгрөгөөр;

1.2.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800805 төслийн кодтой Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км /Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **106,868.4 сая** төгрөг, санхүүжих дүн **20,036.4 сая** төгрөгөөр;

1.3.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800888 төслийн кодтой Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Зүүн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **60,156.2 сая** төгрөг, санхүүжих дүн **18,046.9 сая** төгрөгөөр;

1.4.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **170,899.7 сая** төгрөг, санхүүжих дүн **25,635.0 сая** төгрөгөөр;

1.5.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800770 төслийн кодтой Хатгал-Ханх чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замын эхлэл /Хөвсгөл/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **41,350.1 сая** төгрөг, санхүүжих дүн **10,100.0 сая** төгрөгөөр;

1.6.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400215 төслийн кодтой Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **8,396.8 сая** төгрөг, санхүүжих дүн **3,778.9 сая** төгрөгөөр;

1.7.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400239 төслийн кодтой Спорт заалын барилга /Хөвсгөл, Түнэл сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **2,156.8 сая** төгрөг, санхүүжих дүн **970.6 сая** төгрөгөөр;

1.8.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400052 төслийн кодтой Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **6,728.8 сая** төгрөг, санхүүжих дүн **2,018.7 сая** төгрөгөөр;

1.9.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606700065 төслийн кодтой Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **14,368.5 сая** төгрөг, санхүүжих дүн **4,310.6 сая** төгрөгөөр;

1.10.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400522 төслийн кодтой Спорт заалын барилга /Ховд, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,103.4 сая** төгрөг, санхүүжих дүн **1,396.6 сая** төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Санал хураалтад 7 гишүүн оролцож, 7 гишүүн татгалзаж энэ санал дэмжигдсэнгүй.

2.Багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор дараах төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааг хойшлуулах буюу хөрөнгийн зардлыг 53,045.4 сая төгрөгөөр бууруулах. Үүнд:

2.1.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200838 төслийн кодтой Гадаадын иргэн харьяатын газрын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **2,365.4 сая** төгрөг, санхүүжих дүн **1,064.5 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

2.2Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200992 төслийн кодтой Дотоод хэргийн их сургуулийн цогцолборын Хилийн албаны сургуулийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **21,343.2 сая** төгрөг, санхүүжих дүн **6,403.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

2.3.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200865 төслийн кодтой Хилийн цэргийн 0243 дугаар ангийн авто гарааж, авто засварын барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,017.2 сая** төгрөг, санхүүжих дүн **1,357.8 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

2.4.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200851 төслийн кодтой Хилийн цэргийн 0257 дугаар ангийн спорт заалны барилга /Хөвсгөл, Мөрөн сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,078.5 сая** төгрөг, санхүүжих дүн **1,385.4 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

2.5.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200837 төслийн кодтой Хилийн цэргийн ангийн албан хаагчдын орон сууцны барилга /Хөвсгөл, Цагаан-Уул сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **6,534.9 сая** төгрөг, санхүүжих дүн **1,960.5 сая** төгрөг;

2.6.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200991 төслийн кодтой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны, цагдан хорих байрны барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **6,467.8 сая** төгрөг, санхүүжих дүн **1,940.4 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

2.7.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200355 төслийн кодтой Цагдаагийн газрын барилга /Булган, Булган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **5,353.6 сая** төгрөг, санхүүжих дүн **1,606.1 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

2.8.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200382 төслийн кодтой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны, цагдан хорих байрны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,968.3 сая** төгрөг, санхүүжих дүн **1,785.7 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

2.9.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200517 төслийн кодтой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга /Өвөрхангай, Хархорин сум/, хэрэгжих хугацаа

2026-2028 он, төсөвт өртөг **14,609.5 сая** төгрөг, санхүүжих дүн **3,652.4 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

2.10.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400274 төслийн кодтой Зэвсэгт хүчний дүгээр ангийн тусгай сургалт бэлтгэлийн төв /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,471.6 сая** төгрөг, санхүүжих дүн **1,562.2 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

2.11.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400285 төслийн кодтой Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Баруун бүс/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **19,657.7 сая** төгрөг, санхүүжих дүн **7,942.4 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

2.12.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400293 төслийн кодтой Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **26,586.5 сая** төгрөг, санхүүжих дүн **7,976.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

2.13.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400232 төслийн кодтой Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **20,132.1 сая** төгрөг, санхүүжих дүн **9,000.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

2.14.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601501960 төслийн кодтой Шинжлэх Ухаан Тенологийн Их Сургуулийн оюутны дотуур байрын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **18,030.0 сая** төгрөг, санхүүжих дүн **5,409.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа.

Санал хураалт.

Санал хураалтыг явуулъя.

Санал хураалтад 7 гишүүн оролцож, 7 татгалзаж эдгээр санал дэмжигдсэнгүй.

3.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын урсгал зардлыг бууруулах хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн тооцооллын хавсралт №15-д тусгагдсан зээлийн хүүгийн татаас буюу Шинэ хоршоо-чинээлэг малчин хөтөлбөрийн зээлийн хүүгийн дэмжлэг **108,954.0 сая** төгрөгийг хасаж, гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа.

Санал хураалт.

Санал хураалтад 7 гишүүн оролцож, 7 гишүүн татгалзаж, энэхүү санал дэмжигдсэнгүй.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлгийг хийсэн талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна аа.

Би Цогтбаатар танилцуулна.

Хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Батжаргал дарга та саналаа та микрофон дээр хэлчих. Батжаргал даргын микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд бид эргэж харах ёстой юм байна. Төсвийн байнгын хороо тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэж байгаа ажлын хэсгийн санал, дүгнэлт Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны энэ хоорондын ажлын уялдааг хангахгүй бол нийгэмд ташаа мэдээллүүд яваад байх ийм нөхцөлийг бүрдүүлээд болж өгөхгүй байна. Бид ажлын хэсэг дээр ажиллацгаагаад ерөөсөө төсвийнхөө хүрээнд зохицуулалт хийж болох бүхий л асуудлаа шийдээд Төсвийн байнгын хороо руугаа оруулахаар шийдчихсэн. Тэрийгээ бүгд энэ манай Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүд мэдэж байгаа учраас энд давхардуулж янз бүрийн байр сууринаас санал хураалтад оролцож дэмжихгүй байгаад байгаа байхгүй юу. Гэтэл нийгэм маань өнөө багш нарынхаа, эмч нарынхаа, ахмадуудынхаа цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар ярьж хөөрсөн, хэлэлцээрт нэмэлт оруулсан энэ тэр асуудлуудаа шийдэхгүй хаяж байна гэсэн ойлголтыг өнөөдрийн энэ хуралдаан бий болгохоор болчхож байгаа байхгүй юу.

Тийм учраас Төсвийн байнгын хорооны хуралдаан дээр яригдсан хэлэгдсэн зүйлүүд бүгд зохицуулалт юмнуудаа хийгдээд авсан. Тэгэхээр цаашид энэ Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хурал үйл ажиллагааг илүү хариуцлагатай үр дүнтэй байлгах үүднээс энэ хоорондын уялдааг хангасан зохицуулалтыг нь Дэгийн тухай хуульдаа эргэж харах шаардлага байна шүү. Энүүнийг манай Зарлагын хяналтын дэд хорооны гишүүд, Төсвийн байнгын хорооны гишүүд бас нэг хоорондоо ярилцаж зөв болгох талын арга хэмжээ авах ёстой юм байна гэж ингэж ойлгогдож байна. Энүүнийг би ерөнхий саналаар өнөөдрийн хуралдааны тэмдэглэлд үлдээж байна.

Да.Цогтбаатар: Батжаргал гишүүн санал хэллээ. Саяын Улсын Их Хурлын гишүүн Номин, Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын зарчмын зөрүүтэй саналаар санал хураалгасан ажлууд, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос гарсан ажлын хэсгийн ярилцсан асуудалтай давхардаж байгаа учраас Төсвийн зарлагын хяналтын хорооны гишүүд олонхоороо дэмжээгүй гэдгийг зөвөөр ойлгох ёстой.

Тэгээд энэхүү асуудлууд Төсвийн байнгын хорооны хурал дээр дахин ярилцана гэдгийг та бүхэнд дахин дуулгая. Ингээд хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Төсвийн зарлагын хяналтын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье ээ. Хүрэлцэн ирсэн гишүүд болон ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

10.57 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА